



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар Б/22


Улаанбаатар хот

Б.Бадамдоржид цалинтай чөлөө,  
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.16, 6.9.14, 7.3.12-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтэн Батжаргал овогтой Бадамдоржийн эхнэрийн эрүүл мэндийн хүнд өвчтэй шалтгаан, ар гэрийн аргагүй байдлыг харгалзаж үзэж, 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 1 сарын цалинтай чөлөө, нэг удаагийн буцалтгүй тусламж 1,000,000 төгрөг /нэг сая/-ийг тус тус олгосугай.
2. Буцалтгүй тусламжийн зардал 1,000,000 төгрөг /нэг сая/-ийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Б.Бадамдоржийн албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Дөлгөөн/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР